

хуваан үзэж болох юм. Монголын түүхий эд голлосон экспортын бүтцийг өөрчлөхөд Япон, Өмнөд Солонгосын хамтын ажиллагаа нэн шаардлагатай. Экспортын нөөцийг тогтоох, анхан шатны боловсруулалт хийх замаар бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэх, зам тээвэр, харилцаа холбооны дэд бүтэц төдийгүй, банк санхүүгийн дэд бүтцийг ч хөгжүүлэхэд Зүүн хойд Азийн бүс нутгийн орнуудын хамтын ажиллагаа тулгамдсан асуудал болж хувираад байна.

ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА

**ӨМНӨД, УМАРДЫН ХАРИЛЦААНД
ХӨГЖЛИЙН ОНОЛ БОДЛОГЫГ
ХАРГАЛЗАХ ТАЛААР ЗАРИМ БОДОЛ**

*** Б. Намсрай
П. Доржсүрэн**

Монгол орон үйлдвэрлэлийн уналт үргэлжилж, үндэсний валютын солилцооны ханш нэн доогуур байгаагийн улмаас нэг хүн амд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүний үзүүлэлтээр хэмжсэн, хөгжлийн түвшингээр Өмнөдийн буурай хөгжилтэй орнууд, тэр ч байтугай зарим тооцоогоор бараг л нэн буурай хөгжилтэй орон (LLDC) гэдэг бүлэгт багтах болж байна. Энэ байдлаас хэрхэн гарах хөгжлийн стратеги, үзэл баримтлал боловсруулж, хэрэгжүүлэх нь өнөөдөр цаг үеийн нэн чухал зорилт болж байна.

Ингэхдээ Монгол Улс өөрийн хүлээх хариуцлагыг гүйцэд ухамсарлаж, үүнийгээ тод харуулах ёстой. Энэ хариуцлага нь юуны түрүүнд хөгжилд тус дөхөм үзүүлэх ерөнхий нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Улс орны өөрийн чармайлтыг хандивлагч орнууд орлож, чадахгүй, тэгэх ч ёсгүй. Хөгжингүй Умартын орнуудын засгийн газар

1 Нэн буурай хөгжилтэй орон ("Least developed countries LCD) гэдэг ойлголт 1971 онд НҮБ нэн ядуу орныг ялгах зорилгоор нэвтрүүлсэн.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей НҮБ-ын хөгжлийн төлөвлөлтийн хороогоор шалгаж тогтоосны дараа LDC жагсаалтад тухайн орон орох эсэхийг шийддэг, Ингэхдээ энэ хороо гурван үзүүлэлт, хүн ам тутамд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, ДНБ-д аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин, бичиг үсэг мэдэх хэр хэмжээ гуравт тулгуурладаг. Үүнийг хэрэглэх маяг бас үе үе өөрчлөгдөж байдаг, Сүүлчийнх нь 1989 оных бололтой. Одоо үед ДНБ хүн ам тутамд 473 US доллараас бага, ДНБ-дэх аж айлдвэрийн секторын хувь 10 хувиас доош, хүн амын бичиг үсэг үл мэдэгсдийн хувь 15 жил гаруй хугацаанд 20 хувиас доош байх ийм үзүүлэлт байна. Сүүлийн 2 үнэлгээ байгаа бол нэг хүнд ногдох ДНБ 567 US доллар байвал LDC орныг тодорхойлох шалгуурын талаар НҮБ-ын эрх мэдэл бүхий байгууллагад хэлэлцүүлэг маргаан хийгдсээр байна.

Монгол орны хувьд гэвэл оны үнээр ДНБ 1990 онд 10465,0 сая төг, 1991 онд 18909,6 сая төг, 1992 онд 47298,0 сая төг байна. Монголын эдийн засаг, нийгэм 1992 онд статистикийн эмхтгэл, 11 дэх тал) Үүнийг өнөөдрийн долларын дундаж ханшаар үнэлбэл ДНБ 1992 онд нэг хүнд 53,6 \$ орчим ногдож байна.

эдийн засгийн хувьд бүтээх чадвартай, социал байдлын хувьд харьцангуй тэгш нийгмийн байгууллыг эрмэлзэж буй орнуудын бодлогыг илүү дэмжиж байдаг. Хэрэв ямар нэгэн хөгжиж буй орон хүний хувийн санаачлагыг дарангуйлж байх юм бол, түүний дотор, жишээлбэл, мэдээлэл чөлөөтэй олж авах эрхийг хязгаарлаж байх юм бол гаднаас үзүүлэх тусламж үр нөлөө үзүүлж чадахгүй гэж хөгжингүй орнууд үздэг билээ. Зах зээлийн эдийн засагт тууштай шилжиж чадахгүй, хуучинтайгаа зууралдаж, хүний эрхийг хүндэтгэх явдлыг баталгаажуулж чадахгүй байгаа орнууд хөгжлийн тусламжинд найдах боломжгүй юм.

Үйлдвэржсэн Умардын орнуудын хүлээх хариуцлага нь инфляциас чөлөөтэй урт хугацааны өсөлтийг баталгаажуулах, түүнчлэн хөгжиж буй орны бүтээгдэхүүнд зах зээлээ нээлттэй байлгах, цаашид нээж өгөхөд оршино. Хөгжиж буй орнууд, ялангуяа дунд зэргийн орлоготой орны хувьд худалдаа нь тусламжаас чухал байдгийг харгалзах нь чухал юм. Өнөөдөр хөгжингүй орнууд ҮНБ-ийхээ барагцаалбал 0,36%-ийг хөгжлийн тусламж болгон олгож байна. (Хавсралт 1-ийг үзмүү)

Хөгжиж буй орнуудад *ядууралтай тэмцэх нь* хөгжлийн тусламжийн гол зүйл болж байна. Ингэхдээ ч гэсэн өөртөө туслахад нь туслах явдлыг гол болгодог. Өөр бусад чиглэл гэвэл *хоол хүнсийг баталгаажуулах, хөдөө нутгийг хөгжүүлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах, хүн амын өсөлтийг хязгаарлах, эрчим хүчний хангамж, түүнчлэн боловсрол, сургалтыг сайжруулах* явдал юм.

Хөгжингүй орнуудын хөгжлийн тулгамдсан нэг зорилт нь *эмэгтэйчүүдэд тус дөхөм үзүүлэх*, тэднийг хөгжлийн үйл явцад тэгш эрхтэй татан оролцуулах, хөгжлийн төслийг төлөвлөж, хэрэгжүүлэхэд бүрэн дүүрэн хамруулах явдал байдаг.

Хөгжлийн тусламжийг түргэн үр нөлөөтэй ашиглахад эдгээр гол чиглэлийг харгалзаж ажиллах үндэсний бодлого хэрэгжүүлж чадвал түүний үр нөлөө илүү байхсан.

Хөгжийн бодлого бол үлэжхэн эрүүл саруул байдлыг шаардаж байдаг. Энэ нь бас зайлшгүй шаарддаг, бэлэн байдал, чадвар, өөртөө шүүмжлэлтэй хандах, үүнд суралцах явдал, түүнчлэн ихээхэн эрэлхэг зориг шаарддаг зүйл гэж нэг нэрт улс төрч хэлсэн байдаг.

Өнөөдөр үзэл суртлын сөргөлдөөн, Өрнөд-Дорнодын маргалдаан конфликт шувтарч, олон арван жилийн туршид төмөр хөшигний цаана оршсон Монгол орон дэлхийн аль ч оронтой шууд харилцах сайхан боломж нээгдлээ. Ийм нээлттэй орчинд хөл алдахгүйн тулд хөгжлийн цэгцтэй үзэл баримтлал, бодлого үгүйлэгдэж байна. хуучин цагт тийм боломж алга байсан. 1980, 1982 онд тэр үеийн Монголын

Гадаад явдлын яамны ажилтан зарим хүмүүсийн санаачлагаар хөгжлийн шинэ үзэл баримтлал, түүний роль, хөгжлийн альтернатив замын асуудлаар ЮНЕСКО, ЮНИТАР буюу НҮБ-ын сургалт, судалгааны институттэй хамтран мэргэжилтний уулзалт, симпозиум зохион байгуулж, түүнд дэлхийн нэрт эрдэмтэд оролцож, хэрэв манай тал хүлээж авдагсан бол онолын өндөр түвшинд боловсруулсан сайхан илтгэл, айлтгал тавьж байсан билээ. Манай Монголын талаас бодитой буурьтай судалгаа хийхээсээ илүү капиталист бус хөгжлийн тухай улигт домгийг сэргүүлж байсан нь харамсалтай. Бидэнд олдсон Ийм сайхан завшааныг дахин алдах эрх бидэнд байхгүй.

Ингэхдээ. Хөгжлийн асуудлыг өнөөдрийн тогтолцооны трансформацийн асуудалтай нягт уялдуулж, үзэл баримтлал, бодлого боловсруулахын чухлыг цохож тэмдэглэмээр байна. Монголыг бодвол хөгжлийн харьцангуй дээр түвшинд байсан, коммунист тогтолцоонд төдийлөн удаан байгаагүй орнуудын хувьд ч гэсэн ийм тогтолцооны трансформаци явагдаж байна. Тэгэхдээ энэхүү тогтолцооны трансформаци хэр зэрэг амжилттай явагдаж байгааг харуулах шалгуурыг эдгээр орны туршлагад тулгуурлан эрдэмтэд дараахи дөрвөн зүйлээр тодорхойлж байгааг бид бас харгалзууштай бөгөөд өөрсдийн бодлогод тусгууштай. Эдгээр шалгуур гэвэл:

- 1-рт, цаг хугацааны хүчин зүйл,
- 2-рт, зардлын хүчин зүйл,
- 3-рт, хүлээн зөвшөөрөх байдал,
- 4-рт практик чадвар эдгээр болно.

Цаг хугацааны хүчин зүйл гэдэг нь трансформацийн үйл явцад шаардагдах цаг хугацааны хэрэгцээ, үйл явцын үргэлжлэх хугацааг үйлгож байна. Манай Монгол орны хувьд стратегийн бодлого, үзэл баримтлалаас шалтгаалан арай л зүдгүүртэй, удаан явагдах төлөвтэй байна.

Трансформацийн зардлыг тодорхойлох нь нэлээд төвөгтэй байдаг. Хуучин тогтолцоо болох төлөвлөгөөт эдийн засаг өөрт нь байсан үр ашиггүй байдлыг зайлуулахтай холбогдсон зардал нь трансформациас шалтгаалсан зардалд хамаарахгүй юм. Ийм зардал нь хангамжийн дутагдал, бүтээгдэхүүний чанар муу байгаа, зогсонги байдал, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг хэлбэрээр илэрдэг. Хуучин тогтолцооноос шалтгаалсан үр ашиггүй байдлыг зайлуулах нь тогтолцооны трансформацийн зорилго байдаг бөгөөд энэ нь институци, үйлдвэрлэл, хуваарилалтын бүтцийн их өргөн өөрчлөлтийг шаарддаг, ийм өөрчлөлт нь зардал, ашигт чанарын аль алинтай холбоотой байдаг.

Трансформацийн буюу шилжилтийн зардал нь чухамдаа трансформацийн бодлогоос шалтгаалсан зардал байх ёстой. Энэ нь трансформацийн бодлогоос үүдэн гарсан зардал.

Хүлээн зөвшөөрөх байдал буюу акцептанцийн шалгуур гэдэгт тогтолцооны өөрчлөлтийг хүн ам хэр зэрэг зөвшөөрч, санал нийлж байгаатай холбоотой ойлгодог. Трансформацийн үйл явцыг зөвшөөрсөн, няцаасан харьцаагаар үүнийг тодорхойлж, эр нь трансформацийн нийт үеийн туршид нэгээс аль болох их байх ёстой. Иймд энэ харьцааг нэмэгдүүлэх нь улс төрийн удирдлагад итгэх итгэл, хувь хүнд учирсан байдал, хуучин тогтолцооноос татгалзах юмуу, түүнийг санагалзах, улс төрийн боловсрол, ирээдүйгээ хэрхэн хүлээж буй зэрэг зүйлээс хамаарч байдаг.

Практик чадвар гэдэг нь трансформацийн тодорхой үзэл баримтлалыг бодлого болгон хэрэгжүүлэх байдал, тухайлбал бодлогын тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх, техникийн талаар хэрэгжүүлэх явдлыг ойлгодог. Эдгээр шалгуурыг оновчтой ашиглаж, шилжилтийн бодлогыг хянаж байвал бас трансформацийн үйл явцын амжилтанд эерэг нөлөөлөх боломжтой.

Улс орон	1978-1980 оны дундаж		1980		1985		1986		1987		1988		1989	
	сая US доллар	ҮНБ-ий %	сая US доллар	ҮНБ-ий %	сая US доллар	ҮНБ-ий %	сая US доллар	ҮНБ-ий %	сая US доллар	ҮНБ-ий %	сая US доллар	ҮНБ-ий %	сая US доллар	ҮНБ-ий %
Австрали	628	0,52	667	0,46	749	0,48	752	0,47	627	0,34	1101	0,46	1020	0,38
Австри	154	0,23	178	0,23	248	0,38	198	0,21	201	0,17	301	0,24	282	0,23
Бельги	591	0,54	595	0,50	440	0,55	547	0,48	687	0,48	601	0,39	703	0,46
Канад	1064	0,47	1075	0,43	1631	0,49	1695	0,48	1885	0,47	2347	0,50	2320	0,44
Дани	443	0,72	481	0,74	440	0,80	695	0,89	859	0,88	922	0,89	937	0,94
Финланд	85	0,20	110	0,22	211	0,40	310	0,45	433	0,49	608	0,59	706	0,63
Франц	3439	0,60	4162	0,63	3995	0,78	5105	0,70	6526	0,74	6865	0,72	7450	0,78
Герман	3102	0,42	3567	0,44	2942	0,47	3832	0,43	4391	0,39	4731	0,39	4949	0,41
Ирланд	28	0,18	30	0,16	39	0,24	62	0,28	51	0,19	57	0,20	49	0,17
Итали	444	0,13	683	0,15	1098	0,26	2404	0,40	2615	0,35	3193	0,39	3613	0,42
Япон	2751	0,27	3353	0,32	3797	0,29	5634	0,29	7342	0,31	9134	0,32	8949	0,32
Нидерланд	1392	0,90	1630	0,97	1136	0,91	1740	1,01	2094	0,98	2231	0,98	2094	0,94
Шинэ Зеланд	65	0,33	72	0,33	54	0,25	75	0,30	87	0,26	104	0,27	87	0,22
Норвеги	423	0,90	486	0,87	574	1,01	798	1,17	890	1,09	985	1,13	917	1,04
Швед	911	0,85	962	0,78	840	0,86	1090	0,85	1375	0,88	1534	0,86	1799	0,97
Швейцари	213	0,22	253	0,24	303	0,31	422	0,30	547	0,31	617	0,32	558	0,30
Их Британи	1825	0,43	1854	0,35	1530	0,33	1737	0,31	1871	0,28	2645	0,32	2787	0,31
АНУ	5829	0,24	7138	0,27	9403	0,24	9564	0,23	9115	0,20	10141	0,21	7659	0,15
Нийт ДАС орон	23387	0,36	27296	0,37	29429	0,35	36663	0,35	41595	0,34	48117	0,36	46680	0,33